



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/356

Есөнбулаг

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/439 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, эвдэрч эзэнгүй орхигдсон талбайд хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд: (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
(Байгаль орчин аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн)
(Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч)

(Сумын байгаль хамгаалагч)

(Сумын иргэдийн төлөөлөл)

(Нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгжийн төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, нөхөн сэргээсэн талбайг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

